

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-27

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэх	8-11
2. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Улсын дээд шүүхээс ирүүлсэн саналыг хэлэлцэх	11-18
3. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Улсын Их Хурлаас ирүүлсэн саналыг хэлэлцэх	18-22
4. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	22-24
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/	24-27

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 59 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн;
Тасалсан: Б.Дэлгэрсайхан.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдаанд оролцов.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нэр дэвшигчдийн талаарх асуудлыг хэлэлцэх асуудлын 1 дүгээрт хэлэлцэх санал гаргав.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Э.Энхтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар цэцийн гишүүнээр Э.Энхтуяаг томилуулах тухай саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Эрдэнээгийн Энхтуяаг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Улсын дээд шүүхээс ирүүлсэн саналыг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч О.Мөнхсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг цэцийн гишүүнээр О.Мөнхсайханг томилуулах тухай саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Одонхүүгийн Мөнхсайханг томилох тухай Улсын дээд шүүхийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 17 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах Улсын Их Хурлаас ирүүлсэн саналыг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Л.Өлзийсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар цэцийн гишүүнээр Л.Өлзийсайханг томилуулах тухай саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигч Л.Өлзийсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр Лувсандоржийн Өлзийсайханг томилох тухай Улсын дээд шүүхийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг, мөн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор С.Гантулга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, мөн газрын мэргэжилтэн Ц.Лхагвацэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Д.Цогтбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй нь цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал:**

Д.Цогтбаатар: Төслийн 2 дахь заалтын 21.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Мөрдөн шалгах” гэсний өмнө “Шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, мөн албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, Нийслэлийн орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Д.Авирмэд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар техникийн саатлын улмаас санал хураалтыг гар өргөж хураах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “торгох шийтгэл” гэсний өмнө Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан “оногдуулсан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
16 цаг 59 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн мэндийг эрье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Байнгын хорооны гишүүдээс Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн байна. Норовын Алтанхуяг гишүүн ирсэн байна. Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Дашдондогийн Ганбат гишүүн ирсэн байна. Цэндийн Мөнх-Оргил гишүүн ирсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн гэсэн ийм ирцтэйгээр 57,9 хувийн ирцтэйгээр хурлын ирц бүрдлээ. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал. 1-д, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

2-т, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд,

3-д, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Ингээд бусад асуудалд дараах асуудлууд орж ирж байна.

4-д, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах санал,

5-д, Улсын Дээд шүүхээс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах санал

6. Монгол Улсын Их Хурлаас ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах санал гэсэн ийм 6 асуудал байна.

Тэгээд энэ 6 асуудал дээр надад нэг ийм санал байна. Энэ нөгөө дараах бас яг ажлын юунууд шаардлагаар асуудал оруулж байгаа зарим гишүүдээс хүсэлт гаргаж байна. Тэгэхээр дэс дараалалд нь 1 өөрчлөлт оруулмаар байгаа юм, 1.

2-т, энэ 2 дугаар асуудал Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор өргөн мэдүүлсэн хууль,

түүнтэй холбогдсон бусад хуулиудын хэлэлцүүлгийн энэ 2 дугаар асуудлыг бол бүр хойшлуулах санал байгаа. Яг хариуцсан сайд нь ирэхээр энэ асуудлыг хэлэлцье.

Тэгээд хэлэлцэх эхний асуудал дээр энэ цэцэдтэй холбогдсон 3 асуудлаа оруулж шийдчихээд, тэгээд дэс дараагаараа дараагийн асуудлууд руу оръё гэсэн ийм санал байна. Энэ дээр өшөө энэ хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу? Тэгвэл саяын энэ дэс дараагаараа хэлэлцэх асуудлыг шийдье.

Тэгвэл ингээд 1 дүгээр асуудал нь холбогдох яам, газрынх нь хүмүүс байна уу? Ерөнхийлөгчийн Тамгын газраас оруулсан саналыг шууд хэлэлцээд явъя.

Цэцийн асуудлаас шууд эхлээд явчихъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын тэгье, би юу ч гэсэн танилцуулчихъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг хэлэлцье.

Ингээд нэр дэвшигчийн танилцуулгыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна. Содоо даргыг урья. Содбаатар дарга. Нэр дэвшигчийн танилцуулгыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна. Содбаатар даргад микрофоныг нь өгье.

Я.Содбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.1 дэх, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн

Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 16 дугаар захирамжаараа Эрдэнээгийн Энхтуяаг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэхэд заасны дагуу нэр дэвшигч Эрдэнээгийн Энхтуяаг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Хойд овогтой Эрдэнээгийн Энхтуяа нь 1977 онд Улаанбаатар хотод төрсөн, 46 настай, нөхөр хүүхэдтэй хамт амьдардаг. 1995 онд Ховд аймгийн 10 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургуулийг, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Хууль зүйн ухааны бакалавр, 2005 онд Япон улсын Кюүшү их сургуулийг Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн. Англи, орос хэлтэй.

Нэр дэвшигч Энхтуяа нь 99-2000 онд Ховд аймгийн Прокурорын газрын нарийн бичиг, 2000-2001 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газарт бичиг хэргийн эрхлэгч, 2001-2002 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдын туслах, 2002-2012 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2012-2016 онд Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, 2016 оноос Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын даргаар тус тус ажиллаж ирсэн, ажлын туршилагатай байна. Хуульч мэргэжлээр 24 жил ажилласан.

Нэр дэвшигч Эрдэнийг Энхтуяа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан, эрх зүйч мэргэжилтэй, хуульч, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, хууль зүйн улс төрийн өндөр мэргэжилтэй байх

шаардлагыг бүрэн хангаж байна гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгож, нэр дэвшигч Эрдэнэгийн Энхтуяаг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах асуудлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Янгугийн Содбаатар, Ерөнхийлөгчийн хууль зүйн бодлогын зөвлөх Алтангэрэлийн Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Гүррагчаагийн Алтанчимэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Эрдэнэгийн Энхтуяа, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал Одонхүүгийн Мөнхсайхан гэсэн хүмүүс байна.

Дарааллаар нь явна.

Ерөнхийлөгчөөс ирүүлсэн нэр дэвшигчийн танилцуулгыг тараасан байгаа. Ингээд нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Ганбат гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Үндсэн хуулийн цэц гэдэг бол хариуцлагатай газар. Үндсэн хуулийн цэцийн гишүүн гэдэг бол бас хуучин үед бол Үндсэн хуулиа хамгаалах, Үндсэн хуулийнхаа талаар тэнд очиж ажиллах нь бол нэр төрийн хэрэг гэж ойлгож байна. Энэ албан тушаалд ямар хүн санал болгосон бэ? Өөрөө санал санаачилга гаргасан уу? Миний ойлгож

байгаагаар бол Үндсэн хуулийн 9 гишүүнийг 3, 3-аар л Улсын Их Хурлаас 3, Ерөнхийлөгчөөс 3, Дээд шүүхээс 3 байгаа байх. Нэр дэвшигч Энхтуяа маань алинаас нь санал болгож байгаа хүн бэ?

Өмнө нь гишүүн туршилага бий. Үндсэн хуулийн цэц дээр бол сонгуулийн өмнө Сонгуулийн хуулийг өөрчлөх тийм боломж энэ юмыг захиалгаар гаргаж ирдэг. 1.

2 дугаарт, Үндсэн хуулийг засварлах энэ юмыг Үндсэн хуулийг манах ёстой гишүүд нь өмнөх гишүүд чинь тийм алдаа гаргаж байсан. Үүнийг та юу гэж боддог вэ? Тухайлбал, би Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан 22 оны зуны асуудлыг ярих гэж байна.

Нэгэнт бас Ерөнхийлөгчийн зүгээс энэ асуудлыг танилцуулаад орж ирж байгаа болохоор Ерөнхийлөгчийн төлөөлөөд ажиллаж байгаа хүмүүсээс бас нэг зүйлийг бас тодруулчихмаар байна. Сүүлийн үед Монгол Улсын Ерөнхийлөгч рүү их дайрч байна. Та нөхдүүд яагаад хуульд заасан ажлуудаа хийхгүй байна вэ? Монгол Улсын Ерөнхийлөгчийг би бол маш сайн ажиллаж байгаа гэж бодож байгаа. Ялангуяа гуравдагч хөршийн бодлого дээр хэд хэдэн төрийн том айлчлалуудыг хийлээ. Ковидын дараа бол тасраад байсан энэ зүйлүүдийг, гадаад харилцааг бол тэргүүн дипломатчийн хувьд бол маш сайн зохион байгууллаа. Сүүлийн 1, 2 сарыг ийм сайн ажиллаад байхад гадна, дотнын би зохион байгуулалттай байх гэж бодож байна. Ийм байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн институцын нэр хүндийг унагаах ийм ажил хэвлэл, мэдээллээр тасралтгүй явж байна. Та бүхэн энэ тухайн үед нь гарч ирж тайлбарыг нь өгөхгүй ингээд нэг тийм л байх ёстой юм шиг ийм маягаар ужгируулж байна. Хийх ёстой ажлаа хийхгүй байна шүү, нөхдүүд. Бас Монгол Улсын ерөнхий командлагчийн хувьд энэ Монгол Улсын арми, зэвсэгт хүчний нэр хүндийг бол зориуд зохион

байгуулалттай унагаах, Монголчуудыг цэрэг армидаа дургүй болгох ийм ажлуудыг санаатай болон санамсаргүйгээр явуулж байна уу гэсэн ийм байдлууд харагдаж байна. Шат шатны улсууд нь ажил төрлөө хийхгүй байна. Энэ дээр та бүхэн маань яаж анхаарч байна? Жирийн цэргийн амь нас бол юу болж байгаа нь мэдэгдэхгүй ингэчихсэн байна. Энд яагаад хариултыг нь гаргаж ирэхгүй байна. Яагаад тэр эх, эцэгтэй нь аятайхан зөв харьцаж болохгүй байна. Энэ дээр та бүхэн анхаарал тавьж, ингэж ажиллах ёстой улсууд байдаг. Энэ ажлуудаа яагаад хийхгүй байна? Хэрвээ тухай тухай ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Содбаатар дарга хариулъя. 4 дүгээр микрофон.

Я.Содбаатар: Нэр дэвшигч Эрдэнээгийн Энхтуяаг Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар санал болгож байгаа. Та аль институтээс санал болгож байна гэсэн манай Ерөнхийлөгчийн институтээс санал болгож байгаа ийм нэр дэвшигч. Энхтуяагийн хувьд бид нар хэд хэдэн зүйлийг бас онцолж харж дэвшүүлж байгаа гэж бодож байгаа.

1 дүгээрт, Энхтуяа бол хууль зүйн мэргэжилтэй, гадаад, дотоодод хууль зүйн сургууль, зохих шатны сургуулиудыг бүгдийг нь төгссөн. Нөгөө талаасаа бол ялангуяа захиргааны чиглэлээр, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн ийм албан хаагч, өнөөдөр сүүлийн үндсэндээ 7, 8 жил Хууль зүйн яамны Бодлого хэрэгжилтийн газрын зохицуулах газрын даргаар ажиллаж байгаа. 22, 3 жил Хууль зүйн яаманд мэргэжилтнээс нь эхлүүлээд ажилласан мерит зарчмаараа. Ийм боловсон хүчин.

2-т, ер нь бол яах вэ, Үндсэн хуулийн цэцэд явж ирсэн уламжлалын хуулийн заалт байхгүй. Гэхдээ

уламжлалыг харахад бол бас эмэгтэйчүүдийн тодорхой хувь нь Үндсэн хуулийн цэцийн гишүүдээс бас 2-3 нь эмэгтэй байж ирсэн юм байна лээ. Одоо бол Солонгоо гишүүн ганц эмэгтэй ажиллаж байгаа, 9 дотор. Тийм учраас бас ер нь жендерийн юуг бас харж харгалзаж үзье гэж ингэж бодсон.

3-д, ер нь Үндсэн хуулийн өнөөдрийн байгаа бүрэлдэхүүн тэгээд бас энэ захиргаагаар мэргэшсэн ийм хүн хэрэгтэй юм байна гээд хэд хэдэн нөхцөл байдлыг ингэж дүгнэж үзэж байгаад энэ нэр дэвшигчийг дэвшүүлж байгаа. Бид нар бол Үндсэн хуулийн заалт төдийгүй мэргэжлийн хувьд энэ өндөр албан тушаалыг хашаад явах ийм боломжтой нэр дэвшигч ээ гэж ингэж үзэж байгаа юм.

2 дугаар асуудал бол тантай санал нэг байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд төрийн тэргүүний нэр төрийг хамгаалах асуудал ганц заалттай байдаг. Ер нь Монголд албан тушаал хашиж байгаа бүх албан тушаалтнууд Улсын Их Хурлын гишүүнээс эхлүүлээд сайд дарга нарын албан тушаалууд бол хувь хүний болон байгууллагын нууц юугаар хамгаалагддаг явж байгаа болохоос бусдууд нь бол зөвхөн хуулиар нэр төрийг нь хамгаалж байгаа ганцхан институт бол Ерөнхийлөгч. Тийм учраас яагаад гэхээр ингэж яадаг вэ гэхээр гадаад, дотоодод Монгол Улсыг төлөөлөх эрхтэй. Энэ нь хувь хүнийг нь биш тэр төрийн тэргүүн гэдэг, Ерөнхийлөгч гэдэг энэ албан тушаалыг нь гадаад, дотоодод төлөөлөх эрхтэй байдаг ганц албан тушаалтай учраас ингэж Үндсэн хуульдаа зааж ийм хамгаалалт хийсэн байдаг. Энэ агуулгаараа бол Ерөнхийлөгчийн төрийн тэргүүний нэр төрд халдах асуудал бол хуулиар хориотой, хуулийн хамгаалалттай ийм юм байгаа юм гэдгийг тодотгож хэлэх нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Зэвсэгт хүчний салбарт гарсан асуудалтай холбоотой асуудлаар бол

Засгийн газар тодорхой чиглэл хариуцсан байгууллага нь. Тийм учраас төрийн захиргаа юуны хувьд энэ гүйцэтгэх засаглалын байгууллагын хувьд Засгийн газар өнөөдрийн хуралдаанаар авч бид нарт байгаа мэдээллээр бол ажлын хэсэг гаргаж, тодорхой энэ асуудалд анхаарлаа хандуулж ажиллаж байгаа юм байна гэж ингэж ойлгож байгаа гэдгийг тодотгож хэлье.

Ер нь бол бид нар энэ Үндсэн хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг хэвийн хангах, Үндсэн хуулийн цэцийг хууль сахидаг, Үндсэн хуулиа сахих, ер нь хууль сахиж ажиллуулах чиглэлд бид нар бас тодорхой санал санаачилга гаргаж, бас тодорхой ажиллаж байгаа гэдгийг бас та ойлгож байгаа байх гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Ингээд нэр дэвшигчтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Эрдэнээгийн Энхтуяаг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Эрдэнээгийн Энхтуяа нэр дэвшигчид амжилт хүсье.

17.20 цаг

2 дугаар асуудал руугаа оръё.

Улсын Дээд шүүхээс ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг хэлэлцье.

Нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Дээд шүүхийн Иргэний танхимын тэргүүн Гуррагчаагийн Алтанчимэг танилцуулна. Алтанчимэгт микрофон өгье. 6 дугаар микрофон.

Г.Алтанчимэг: Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25, 8, 7 дахь заалтыг тус тус үндэслэн Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг 2023 оны 10 сарын 02-ны өдрийн Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцэж, тус хуралдааны 36 дугаар тогтоолоор Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн олонхын санал авсан Одонхүүгийн Мөнхсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд санал болгохоор шийдвэрлэсэн учраас Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт заасны дагуу Одонхүүгийн Мөнхсайханыг Улсын Их Хурлын Байнгын хорооны хуралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигч Одонхүүгийн Мөнхсайхан 1983 онд Ховд аймгийн Жаргалант сумд төрсөн, 40 настай, ам бүл 4, эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн хүн байна. Мөнхсайхан нь Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа хийж, 2008 онд Япон улсын Нагояагийн их сургуулийн Хуулийн сургуульд хууль зүйн магистр, 2011 онд Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан, МУИС-ийн эрдмийн зөвлөлийн 2019 оны 2 дугаар тогтоолоор дэд профессор цол олгосон. Англи хэлтэй. 2005 оноос эхлээд МУИС-ийн Хууль зүйн сургуульд тэнхимийн туслах ажилтан, багш, дэд профессор, профессороор нийтдээ 18 жил ажиллаж, 2022 оны 01 дүгээр сараас МУИС-ийн Үндсэн хуулийн эрх

зүйн хүрээлэнгийн захирлын албан тушаалыг хавсран гүйцэтгэж байгаа.

Мөнхсайхан нь Үндсэн хуулийн эрх зүй, хүний эрх, шүүх, хуульчийн ёс зүй, эрх зүйн болон улс төрийн философийн хичээлийг МУИС-ийн Хууль зүйн сургуульд мөн хуульч, шүүгчийн үргэлжилсэн сургалтад энэ сэдвээр чиглэлээр хичээл зааж ирсэн хүн байна.

Сүүлийн 10 жилд мэргэшсэн чиглэлээрээ 30 орчим судалгааны төслийг дангаараа болон багаар хэрэгжүүлж, 9 ном, сурах бичиг, 60 гаруй эрдэм шинжилгээний өгүүллийг англи болон Монгол хэлээр хэвлүүлж, 60 орчим судалгааны илтгэл хэлэлцүүлсэн.

Мөнхсайхан АНУ-д Вашингтоны их сургууль болон Жорж Вашингтоны их сургуульд зочин судлаач, Японы Нагоя их сургуульд гадаад судлаачаар ажиллаж байсан.

Ингээд нэр дэвшигч Мөнхсайхан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшигчийн шаардлагыг бүрэн болзол шаардлагыг хангасан, хууль зүйн өндөр мэргэшилтэй, Үндсэн хуулийн эрх зүйн дагнасан судлаач, багш, профессор байгаа учраас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар Монгол Улсын Дээд Шүүхээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэж өгнө үү гэж хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Гүррагчаагийн Алтанчимэг, тэгээд нэр дэвшигч буй хүн нэр дэвшигч өөрөө орж байгаа Үндсэн хуулийн эрх зүйн

хүрээлэнгийн захирал Одонхүүгийн Мөнхсайхан гэсэн 2 хүн байна.

Улсын дээд шүүхээс ирүүлсэн нэр дэвшигчийн танилцуулгыг та бүхэнд тараасан байгаа. Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би Мөнхсайхан багш гэх үү, нэр дэвшигч гэх үү. Нэр дэвшигч багшийг дэмжиж байгаа. Тэгээд өмнө Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн Энхтуяаг ч гэсэн дэмжиж байгаа. Энэ нэг нь судлаач, нөгөөдөх нь практик ажлын арвин туршилагатай 2 хүн дэвшиж байгаа юм байна. Би зөв байх гэж бодож байна.

Мөнхсайхан нэр дэвшигчээс зүгээр нэг л зүйл тодруулах гэсэн юм. Энэ шүүх тэгээд хууль тогтоох байгууллага, тэр дундаа Үндсэн хуулийн шүүх хууль тогтоох байгууллага 2-ын хооронд энэ ер нь зөвхөн Монголд ч биш дэлхийн бүх улс оронд л энэ 1 одоо юу гэдэг юм нэг тэмцэл гэх юм уу, зөрчилдөөн гэх, зөрчилдөөн ч биш юм даа, нэг тулаан л юм даа, байнга явж байдаг л даа. Тэгээд энэ ихэнх орнуудад бол нөгөө шүүхийн идэвхжилт буюу *judicial activism* гэж нэг айхтар феномен байдаг. Зарим улс нь бол энийгээ өнгөрөөчихсөн, зарим улс нь ид дундуур нь явж байдаг. Тэгээд манай Үндсэн хуулийн цэц бол энэ шүүхийн идэвхжилт буюу *judicial activism* гэдгээр сайнаар ярих юм бол халдварлаад, муугаар ярих юм бол өвчлөөд нэлээн хэдэн жил болчихож байгаа юм. Тэр нь шүүхийн идэвхжилт гэдэг нь яг хуульд нь өөрийнх нь эрх хүрээнд бүрэн заагаагүй, тэгэхдээ байж болохоор ч юм шиг. Түүн дээр шүүх нь өөртөө эрх оноож аваад л энэ бол манайд байж болно, бид нар бол энийг юу гэдэг юм, шүүхийн асуудал цэцийн хэлэлцэх асуудал мөн гэж үзэж байна гээд л. Ингээд л шийдээд явчихдаг нэг айхтар идэвхжилт байгаа юм л даа. Тэгэхээр Мөнхсайхан багшаас та энэ ер

нь Монгол Улсад Үндсэн хуулийн цэцийн шүүхийн идэвхжилт зохих түвшиндээ байна гэж үздэг хүн үү. Эсвэл зохих түвшиндээ арай хүрээгүй цаашаа ч гэсэн үргэлжлэх ёстой гэж үздэг хүн үү? Энэ дээр нэг яг хувь хүнийхээ судлаачийнхаа хувьд санал дүгнэлтээ хэлээч.

Нөгөө томилогдоод явсны чинь дараа бол ийм асуулт асууж чадахаа байчихна л даа. Шүүхийн үйл ажиллагаанд оролцсон, нөлөөлсөн гэдэг хардалт сэрдэлтэд орох учраас. Үүний жишээ нь хамгийн тод жишээ бол Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуультай нийцэж байна уу, үгүй юү гэдгийг зөвхөн хэлбэр талаас нь бус агуулга талаас нь Дээд шүүх, Дээд шүүх гэнэ, Үндсэн хуулийн цэц хянах эрхтэй гээд. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуульд хаана нь ч заагаагүй гаднын зарим орнуудад хэрэгжээд, маш их асар их маргаан дагуулж, байгаа үндсэн бүтцийн номлол буюу бэйс экстракшн тогтен гэдэг юмыг Цэцийнхээ дүгнэлтэд нэг өгүүлбэр зааж өгөөд л үндсэн бүтцийн онолын дагуу манайх ийм эрхтэй гэх мэтээр ингээд олон жишээнүүд байгаа юм л даа. Энэ дээр би зүгээр яг энэ асуудлаар нь ярьж байгаа юм биш шүү, зүгээр жишээ болгож хэлж байгаа юм. Тэгэхээр энэ маргаантай байгаа асуудал дээр бол та өөрийнхөө байр суурийг илэрхийлж болохгүй байх, хэрэггүй. Ер нь зүгээр энэ шүүхийн идэвхжилт дээр *judicial activism* дээр та нэг байр сууриа хэлээч? Энэ ялангуяа манай Цэц дээр байгаа юм. Дээд шүүх дээр бол ийм асуудал байхгүй. Баярлалаа. Тэгээд дэмжиж байгаа, 2 нэр дэвшигчээ%

Д.Цогтбаатар: Мөнхсайхан нэр дэвшигчээс өөрөөс нь асуусан, 7 дугаар микрофон өгье.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ Үндсэн хуулийн хяналт гэдэг ойлголт бол 1803 онд анх бий болсон. Тэгээд үүссэн цагаасаа хойш анх

Америкт үүсээд тэгээд 1920 оноос хойш Европт Европ загвараар дэлгэрсэн. Тэгээд энд бол хамгийн тулгамдаж байгаа дотор нь дандаа яригддаг асуудал бол яах аргагүй ард түмнээс сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдсэн парламентын баталсан хуулийг Үндсэн хуулийн нэрийг бариад Үндсэн хууль зөрчсөн учраас хүчингүй болгох ийм эрх мэдлийг Үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлэх нь зөв үү, үгүй юү гэдэг ийм асуудал яригддаг. Энэ хүрээнд парламент Үндсэн хуулийн шүүх 2-ын харилцаа ер нь бол нэлээн ийм ээдрээ төвөгтэй, тал талаас нь анхаарч хандах ийм асуудал практик судалгаа аль алин дээр нь яригдаж байгаа юм.

Манай Үндсэн хуулийн цэцийн хувьд яг тоог нь харах юм бол активизм бол харагдахгүй. Яагаад вэ гэхээр Үндсэн хуулийн цэц бол жилд дунджаар 10 орчим маргаан шийддэг. Өнгөрсөн 31 жилийн хугацаанд 230 гаруй маргааныг шийдсэн, яг агуулгаар нь шийдсэн тоог нь харах юм бол. Өөрөөр хэлэх юм бол дунд суудал, их суудал аль алинаар нь орсныг нэгд тооцоод харах юм болбол. Гэтэл бусад улсуудын Үндсэн хуулийн шүүх бол жилд зарим нь бол 200 орчмыг шийддэг, 1 жилд. Тэгээд тэгэхээр тоо нь харьцангуй яг маргааны агуулга шийдэж байгаа нь цөөн. Агуулга дээр нь сая бол гишүүн өөрийнхөө бас байр суурийг илэрхийлж байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг 2022 онд хянасан асуудал дээр. Энэ дээр цэцийн тухай хуулиар цэц дээр хянан шийдвэрлэгдэх асуудлаар урьдчилсан байр сууриа илэрхийлэхийг хориглодог учраас миний хувьд бол одоо нэр дэвшигчийн статус дээрээс саяын асуудал дээр бол байр суурь хэлэх боломж хараахан алга байна. Гэхдээ энд анхаарах 2 зүйл байгаа юм.

1 дүгээрт, зарчим болон бодлого 2-ыг ялгах ёстой гэж бол онол практикийн хувьд үзэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуулийн шүүх бол Үндсэн хуульд байж байгаа зарчим, тэр зарчмыг хэрэглэж

маргааныг шийдэх ёстой. Тэр нь хууль дээдлэх зарчим, шүүхийн бие даасан байдал ч гэдэг юм уу. Бодлого гэдэг юу вэ гэхээр нийгэм, эдийн засгийн амьдралыг яаж сайжруулах вэ, тэр зорилгод яаж хүрэх вэ гэдэг ийм шийдэл байдаг. Энэ бол ард түмнээс сонгогдсон парламентын тухайн үеийн олонхын шийдэх ёстой зүйл. Тэгэхээр Үндсэн хуулийн шүүх аль болох энэ бодлогын асуудал руу политикал күүшин буюу улс төрийн асуудал руу орохоос татгалзах сэлф констрэйнт гэж хэлдэг. Өөрөө энэ дээрээ тэвчих хязгаараа тогтоох ийм шаардлага бол гарч ирдэг. Энийг бас анхаарах хэрэгтэй юм болов уу гэж бодож байна.

2 дугаарт, Үндсэн хуулийн шүүх ер нь Үндсэн хуулийн хяналттай бүх газар юу вэ гэхээр стaндингийн шаардлага тавьдаг. Өөрөөр хэлэх юм бол тухайн Үндсэн хуулийн шүүхэд хандах гэж байгаа нэг бол иргэний өөрийнх нь эрх зөрчигдөөд ердийн журмаар шүүхэд хандаад хамгаалуулж чадаагүй бол өргөдөл гаргана, гомдол гаргана. Эсвэл төрийн эрх бүхий байгууллага өөрийнх нь ашиг сонирхол хөндөгдсөн бол хамаарлын зарчмаар ханддаг. Гэтэл манайд өнгөрсөн 31 жил Цэцийн тухай хууль тогтоомж хараахан шинэчлэгдээгүй байгаа учраас саяын 2 зүйл бүрэн тусаж чадаагүй байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол иргэн өөрийнхөө эрх зөрчигдсэн эсэхээс үл хамаарч, цэцийн харьяаллын ямар ч асуудлаар Цэцэд хандах боломжтой. Энэ нь өөрөө эргээд Үндсэн хуулийн цэцийг нэлээн улс төрийн маргааны тэр төв рүү оруулах, аль нэг тал руу нь шийдвэр гаргах ийм байдал руу аваачдаг. Тийм учраас Цэцийн тухай хууль тогтоомж шинэчлэн найруулагдах хүрээнд иргэний гаргадаг мэдээлэл, эрх бүхий байгууллага албан тушаалтны гаргадаг хүсэлт, иргэний эрх нь зөрчигдсэн тэр өргөдлийн асуудлыг зохистой зохицуулах замаар саяын баланс бол ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Яах вэ, нэмж хариулах уу? Тэгвэл Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Улсын дээд шүүхээс нэр дэвшиж орж ирж байгаа юм байна. Шүүхийг хараат бус байгаасай, тэр хуулийнхаа дагуу үйл ажиллагаа явуулаасай энэ тэр гээд бүгд л харж байгаа л даа. Би ч өөрөө шүүхийг ийм байлгахын төлөө, үүний төлөө бас зөндөө ажиллаж байсан одоо ч ажиллаж гэж бодож байгаа ийм хууль тогтоогчийн нэг ээ.

Тэгээд танай шүүхээс чинь Үндсэн хуулийн цэцэд бол үнэхээр шүүгч хийж байсан ийм хүн очвол маш хэрэгцээтэй байгаа юм шиг байгаа юм. Үндсэн хуулийн цэцийг бол олон янзаар ярьдаг л даа. Шүүх ч юм шиг, биш ч юм шиг, манаач нь ч юм шиг гээд л. Ингээд иймэрхүү байдалтай байгаа. Гэтэл олон жил шүүгч хийж байсан ийм шүүгч хүн очвол тийм боломж нь Улсын дээд шүүхэд байгаад байдаг. 3 хүнийг тэнд санал болгох боломжтой. Гэтэл та нар маань мэдээж хэрэг Мөнхсайхан нэр дэвшигчийн хувьд хуулийн шаардлага бүрэн хангаж л байна л даа. Нөгөө улс төр, хууль, эрх зүйн өндөр мэдлэгтэй гэдэг талаасаа бол. Та нар маань яагаад ингээд танай шүүхэд нэг их сайн мэдэхгүй ийм хүнээ ингээд оруулаад ирж байгаа юм бэ гэдгийг л би Дээд шүүхээс асууя.

Үндсэн хуулийн цэц яах ийх нь яаж байгаад ингээд оруулчав аа? Эсвэл та нарын хараат байгаагийн нэг илэрхийлэл үү, энэ.

Нөгөө талаар би энэ нэр дэвшигчээс асууя. Мөнхсайхан нэр дэвшигчээс 2019 оноос одоог хүртэл 3 удаа ойр ойрхон Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хуульд өөрчлөлт орсон. Үүний ажлын хэсэгт нь та явж байсан гэж би ойлгоод байгаа. Байнга л байж байсан. 19 онд бол нөгөө 3 тусдаа засаглалыг хийж чадлаа, энэ шиг сайн юм алга гээд

ингээд байж байсан. Нөгөө шүүх хараат бус боллоо, хууль тогтоох нь бас хараат бус боллоо, гүйцэтгэх засаглал нь хараат бус болчихлоо. Энэ ажлыг бид нар амжилттай хийж чадлаа гээд байсан. Тэр ажлын хэсэгт орчхоод тэр хууль зүйн үндэслэлийг та маш сайн тайлбарлаж байсан. Маш сайн залуу байна. Багш, үүнийг тэр оюутнууд нь хараад маш их баярлаж байгаа байх гэж ойлгож байсан. Гэтэл дараалаад 2 өөрчлөлт дээр бас та байсан, бас л маш сайн өөрчлөлт боллоо гээд л ингээд ярьж байсан. Яах вэ, өнөөдөр бол давжаа парламентад давхар дээлтэй байгаа нь бол өнөөдөр үнэхээр энэ иргэдийн бухимдлыг бол маш их хүргэж байна шүү дээ. Хууль тогтоох нь хаанаа байгаа юм, гүйцэтгэх засаглал нь хаанаа байгаа юм. Энэ 2 нь нийлчихээрээ нөгөө хараат бус шүүх нь хаана байгаа юм гээд ийм байдалтай болчихлоо. Энэ дээр та бас тайлбарыг нь тавиад явж байсан. Үүнийхээ хариуг авч байгаа юм ишг ингэж шүүхээр дамжиж очиж байна уу, үгүй юү? Үүнийг та юу гэж бодож байна? Үүнийгээ нэг тодруулаад өгөөч.

Д.Цогтбаатар: Эхний асуулт Дээд шүүхээс байсан. 6 дугаар микрофон өгье.

Г.Алтанчимэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд зааснаар Улсын дээд шүүх Цэцийн 3 гишүүний нэрийг Их Хуралд санал болгох ийм хууль зүйн зохицуулалттай. Энэ Улсын дээд шүүх цэцэд нэр дэвшигчийг хэрхэн яаж нэрийг нь дэвшүүлэх вэ, сонгох вэ гэдэг асуудлыг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны бүрэн эрхэд байдаг. Энэ хуралдааны бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ нийт шүүгчдийн хуралдааны дэгийн дагуу энэ санал дэвшүүлэх ажиллагааг явуулдаг, зохион байгуулдаг. Тэгээд санал дэвшүүлэх ажиллагааг зохион байгуулахын тулд Улсын Дээд шүүхийн Тамгын газар энэ дэгийн дагуу нийтэд Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэрээ

дэвшүүлэхийг санал болгож нийтэд зар тавьдаг. Энэ зарын дагуу иргэн өөрөө болзлоо хангаж байна гэж үзэх юм бол Улсын Дээд шүүхийн Тамгын газар материалаа ирүүлээд, энэ материалыг үндэслээд нийт шүүгчдийн хуралдаан хийж хуралдаанаасаа болзлыг хангаж байна гэж үзсэн, нийт шүүгчдийн олонхын саналыг авсан нэр дэвшигчийг бид нар Улсын Их Хуралд мэдүүлдэг ээ. Тэгэхээр энэ журмын дагуу явж байгаа асуудал, 1 дүгээрт.

2 дугаарт нь, Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд Улсын Дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байгаа хүнийг мэдээж нөгөө Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэхийг бол хориглосон байдаг. Харин Улсын Дээд шүүхэд ажиллаж байгаад ажиллахаа больсон ийм шүүгч нэрээ дэвшүүлэх эрх нь нээлттэй байдаг. Нэр дэвшүүлэх ажиллагаа түрүүний миний дурдсан энэ үндэслэлээр ийм үйл ажиллагаагаар яваад тэгээд олонхын санал авч байгаа бол мэдээж урьд нь Улсын Дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байсан хүн энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгох ийм боломж нь бол байгаа. Ажиллаж байгаа хүний хувьд хориглочихсон байгаа.

Тэгэхээр энэ журмын дагуу 2 удаа хамгийн сүүлд нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаад, 7 сард явсан ажиллагаанд нийт шүүгчийн олонхын саналыг авсан нэр дэвшигч гараагүй учраас 2 дахь удаагаа энэ нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаад, 9 сард энэ материал хүлээж аваад, 2 хүн нэрээ дэвшүүлсний нэг нь Мөнхсайхан нэр дэвшигч байсан. Ингээд олонхын санал авсан учраас өнөөдөр юу Улсын Их Хуралд бид нар саналаа хүргүүлсэн байгаа.

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон.

О.Мөнхсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Миний, би сүүлийн 18 жил энэ Үндсэн хуулийн эрх зүй, хүний

эрх, үүний суурь онолын чиглэлээр бол судалгаа хийж ирсэн. Миний мэргэжлийн хувьд байдаг ганц мөрөөдөл бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн бүр хүн шиг, хүний ёсоор хүндлэгдэж хүн байх шаардлагатай наад захын тэр үндсэн эрх, эрх чөлөөгөө эдэлдэг, хүн бүрд хууль тэгш үйлчилдэг, тэгээд тусгаар тогтносон бие даасан ийм улс болж цогцолж хөгжжөөсэй л гэдэг ийм л хүсэл байдаг. Үндсэн хуулийн эрх зүй үүнийг хамгаалах, бэхжүүлэхэд зориулагдсан ийм салбар эрх зүй. Тэгээд миний хувьд Хууль зүйн сургууль төгсөөд сургуульдаа ажиллаж байгаад, Япон, Америк руу 7 жил судалгаа хийж, ном хэвлүүлэх гэж доктор хамгаалах гэж явсан. Тэгээд 2013 онд буцаж ирснээс хойш энэ судалсан чиглэлээрээ эхлээд дандаа судалгааны бүтээл гаргачхаад түүн дээрээ үндэслэж саналаа өгч ирсэн. Тухайлах юм бол 2013-16 оны үед бол Батбаяр гишүүний санаачилсан, өргөн барьсан төсөл дээр миний хувьд тухайн үед баг бүрдүүлээд, судалгаа хийгээд, ном гаргаад, тайлан гаргаад саналаа өгч байсан. Тэнд бол гишүүдийн тоо, энэ давхар дээл гэж хэлдэг зүйл, шүүх ингээд бүгд нь хөндөгдөж байсан. Тэгээд 2016-19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тэр процесст бол ажлын дэд хэсгийн гишүүний хувьд оролцсон, бас л ахиад дутуу зүйлүүдээ судалж, бусад хүмүүс, судлаачид, энд оролцсон хүмүүстэй хамтраад 19 оны нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, батлахад оролцсон. Энэ ажлын дэд хэсэгт нь ажилласан.

Тэгээд өнгөрсөн 4 жилийн хугацаанд энэ нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх дээр ажлын дэд хэсэгт ажилласан судлаачид бид нарын хувьд бол хуваагдаж ороод ажилласан. Энэ дотроо миний хувьд бол Шүүхийн тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Их хурлын хяналт шалгалтын тухай хууль зэрэг яг өөрийнхөө өмнө нь судлаад ном судлаад гаргачихсан тэр зүйл дээрээ би энэ ажлын хэсгүүд дээр орж саналаа бичгээр өгч гарсан. Энэ дээр бүгдээрээ ном болоод хэвлэгдчихсэн байгаа юм.

Тийм. Тэгэхээр энд ингээд өнгөрсөн 10 жилийг харах юм бол би ямар нэгэн нам, аль нь эрх барьж байна гэдгээс үл хамаараад хэрвээ миний мэргэжсэн чиглэлээр итгээд ажлын хэсэгт оруулах юм бол би чадах бүх боломжоороо судалгаа хийж ингэж саналаа өгч ирсэн. Энэ дээр үнэт зүйлүүдээ үнэнч энэ зарчмаараа явсан гэдэг маань миний энэ хэвлүүлсэн бүтээлүүдээс харагдана байх гэж найдаж байна.

2022 онд Үндсэн хуулийн цэцээс Их Хурлын 4 хүртэл гишүүн Засгийн газрын гишүүнээр хавсарч ажиллахыг зөвшөөрсөн заалтыг бол Үндсэн хууль зөрчсөн гэж хүчингүй болгосон. Энэ дээр бол тухайн үед миний хувьд бас байр сууриа илэрхийлж байсан. Дараа нь ахиад энэ Цэц нэгэнт Үндсэн хуулийн 39.1-д байгаа тэр өгүүлбэрийг хүчингүй болгосон учраас хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн балансыг хангах үүднээс өнгөрсөн 5 сард бол нэмэлт, өөрчлөлт орсон гэж харж байгаа. Гэхдээ миний хувьд Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсэгт бол ороогүй. Гэхдээ та хэрвээ харах юм бол энэ оны 01 сарын 13-ны өдөр би өөрийнхөө яг энэ асуудал дээр мэргэжилтнийхээ хувьд байр сууриа илэрхийлж байсан. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуульд ер нь бол өөрөө 19 оныхоо 19 онд нэмэлт өөрчлөлт оруулсан үүнийхээ үр дүнг үзэх ёстой. Үүнийг дагаж гарах 30 гаруй хуулийн тал нь батлагдсан, тал нь батлагдаагүй байна, үүнийгээ батлах шаардлагатай. Үндсэн хууль бол тогтвортой үйлчлэх хэрэгтэй юм гэдэг талаасаа бол би олон удаа байр сууриа илэрхийлсэн.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнд 1 минутыг нь өгье.

Д.Ганбат: Ерөнхийдөө асуултад хариулж байгаа байдлыг бид бүхэн харлаа. Тэр Бямбацогт гишүүн их яриад байна гэж байх шиг байна. Тийм. Тэгээд энэ болгоноосоо дүгнэлтээ хийгээрэй. Тэр Үндсэн хуулийн цэцэд оччихоод энэ

Үндсэн хуулийг яг хуульчийнхаа үүднээс байхын оронд улам гутгадаг, завааруулдаг, тэгээд ямар нэгэн нам юм уу, хэн нэгний эрх ашигт нийцүүлдэг ийм юмаа бол тэнд очиж болиулахыг оролдоорой. Ерөөсөө үүнээс чинь болж олон зүйл гарч байгаа, үр дагавар нь их хүнд байгаа гэдгийг өөрөө мэдэж байгаа байх. Өнөөдрийн асуулт хариултаас ч гэсэн цааш цаашидаа энэ Үндсэн хуулийн цэцийн гишүүд бол хичээх хэрэгтэй.

Нөгөө талаар бол мэдээж хэрэг ингээд цааш цаашаа алдаа, оноо гаргадаггүй хүн байхгүй. Гэхдээ Үндсэн хуулийн цэцийн гишүүн алдаа гаргахгүй шүү, тэр ажил дээрээ.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Энхбаяр гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Мөнхсайхан докторыг дэмжиж байгаа, очих ёстой хүн, очих ёстой газраа очих гэж байна гэж харж байгаа. Мөнхсайхан багштай бол би тодорхой хуулийн төсөл боловсруулах чиглэлд олон судалгаанууд дээр хамтарч ажиллаж байсан. Хөдөлмөрч хүн. Аливаа асуудалд судалгаа тооцоогүйгээр огт ярьдаггүй, хувийн байр суурь илэрхийлдэггүй, дандаа судалж, дандаа харж, дандаа харьцуулж, дүгнэж байж байр суурь илэрхийлдэг ийм чамбай хуульч юм байна гэж ингэж дүгнэдэг. Хуульч гэхээсээ илүү судлаач хүн. Өнөө цагт бол ялангуяа манай хууль, эрх зүйн салбарт бол маш ховор, манай салбарын бас энэ энэ цагийн хууль зүйн судалгааны бас нэлээн ноён оргилуудын нэг гэж хүндэлж явдаг ийм эрхэм байгаа.

Хамгийн сүүлд Шүүхийн багц хууль дээр 21 онд батлахад бас хамтарч

ажиллаж байсан. Энэ шүүхийн шинэтгэлүүд хүмүүс бол янз бүрээр ярьдаг. Би шүүхийн шинэтгэл үр дүнгээ өгч байгаа гэж үздэг. Өнөөдөр НҮБ-ын тусгай илтгэгч Монгол Улсад 5 жилийн дараа ажиллаад, дүгнэлтээ олон нийтэд нээлттэйгээр танилцуулсан байна. Энэ дүгнэлтдээ 2021 онд хийгдсэн Шүүхийн багц хууль бол шүүх эрх мэдлийг улс төрийн нөлөөллөөс, томилогдсон этгээдээс хараат байдгийг болиулах чиглэлд Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ ажиллах механизмууд, шүүгчийн хараат бус байдалтай холбоотой зохицуулалтуудыг сайшаан тэмдэглэсэн байна лээ. Тэгэхээр энэ бол бас Мөнхсайхан багшийн судалгааны үр дүн гэж харж байгаа, 1.

2-т, энэ шүүхийн шинэ хуулийн дагуу Улсын дээд шүүх 3 дахь Үндсэн хуулийн цэцийн нэр дэвшигчээ тодруулж, өнөөдөр Улсын Их Хуралд танилцуулж байна. Өмнөх 2 цэцэд томилсон хүн нь нэг нь Эрдэнэбулган багш, нөгөөдөх нь Гангабаатар багш. Одоо ингээд Мөнхсайхан багш гээд ингээд манай салбарын хамгийн нэр хүндтэй ийм 3 судлаач өнөөдөр цэцийн гишүүнд бас Улсын Дээд шүүхээс гарч ирсэн байна. Гурвуулаа улс төрийн аль нэг намд харьяалагдаж байгаагүй, гурвуулаа. Гурвуулаа хууль зүйн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, гурвуулаа хар зам, мөр байхгүй ийм хүмүүс гарч ирсэн байгаа нь Монгол Улсын дээд шүүхээс энэ цэцийн гишүүнд нэр дэвшүүлж байх чиглэлд шүүхийн хуульд орсон механизмууд үр дүнгээ өгч байна гэж би хувьдаа дүгнэж явдаг.

Урьд нь энэ шүүхийн хууль гарахаас өмнө жишээлбэл Гончигдорж гээд улс төрч нэр дэвшээд сууж байсан Дээд шүүхээс оччихсон. Яасан, өө дээрээс дарга нэр дэвшүүлж байгаа юм, нам нь нэр дэвшүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл Дээд шүүхийг улс төрийн нам эрх мэдэлтнүүд гартаа атгаж, тэнд хүнээ Цэцийн гишүүнд нэр дэвшүүлдэг байсан. Энэ асуудлыг таслан зогсоосон, Шүүхийн

хуулиар. Үүний үр дүн гарч байна. Манай салбарын 30, 40 хуульчид Үндсэн хуулийн цэцийн гишүүнд Дээд шүүхээс нэр дэвшээд гарч чадаагүй. Олонхын саналаас. Энэ дээд шүүхээс Цэцийн гишүүнд нэр дэвшинэ гэдэг бол ер нь хэр барагтай хуульчийн гардаг тийм асуудал биш болсон. Яагаад гэхээр 25 шүүгч нууцаар санал хураадаг, хэнд өгч байгаа бүү мэд, хэнийг ч хэлсэн бай хараат бусаар гардаг үнэхээр хүлээн зөвшөөрөгдсөн хүн гардаг ийм болсонд баярт ... /минут дуусав/

17.51 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 3 дугаар асуудал.

Монгол Улсын Их Хурлаас ирүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулах саналыг хэлэлцье.

Нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танилцуулна. Занданшатар даргын микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Би нэг цөөхөн үг Мөнхсайхан нэр дэвшигчид хэлчихье. Цөөхөн, би олон юм ярихгүй. Сая Мөнхсайхан нэр дэвшигч ээ, ингэж ярьж байна. Ер нь бол энэ үгүй үгүй би дууслаа. Судалгааныхаа ажлыг та зоригтой үргэлжлүүлээрэй. Монголд бол энэ академик чиглэлийн ялангуяа харьцуулсан эрх зүйн судалгаануудыг бол үнэхээр хийж байх ёстой. Ялангуяа Үндсэн хуулийн чиглэлээр бол энэ судалгаанууд чинь нарийн чамбай улам чамбайрч хийгдэж байх ёстой. Та дандаа сая ажлын хэсгийн гишүүн байсан, том том хуулиудын төслүүд дээр. Одоо бол та Үндсэн хуулийн цэцийн гишүүн болж байна. Монгол Улсын хувь заяаг хуультай нь нийцүүлж, хуулийн үг үсэг, таслалтай нь нийцүүлж энэ Үндсэн хуулийн түвшинд хуулийн хэрэгжилтийг та хангах гол хүмүүсийн нэг болж байгаа. Энэ дээр тэгэхээр тэр хатуу зарчмыг та барьж ажиллаарай. Тэгээд таны ажилд амжилт хүсье. Тэгээд гол нь тэр эрдэм шинжилгээний ажлуудаа битгий зогсоогоорой л гэж хүсмээр байна.

Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Одонхүүгийн Мөнхсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Та ба байна шүү, саналаа өгнө шүү, та.

90 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн Улсын Их Хурлаас Доржийн Одбаярыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр 6 жилийн хугацаагаар томилсон бөгөөд энэ хугацаа дуусгавар болсон тул Одбаяр гишүүний оронд үүнтэй холбогдуулаад Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиудын дагуу Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлаас нэр дэвшүүлж байна.

Лувсандоржийн Өлзийсайханыг нэр дэвшүүлэхдээ 1 дүгээрт, онолын мэдлэг, Үндсэн хууль судалгааны ажил, туршилага, 2 дугаарт, хууль тогтоох, 3 дугаарт, гүйцэтгэх, 4 дүгээрт, шүүх эрх мэдлийн салбарт ажилласан ажлын мэдлэг, ур чадвар, дадлага туршилагыг үндэслэн цэцийн гишүүнд нэр дэвшүүлж байгаа юм.

Үндсэн хууль судлаач, онолын мэдлэгийн хувьд бол Лувсандоржийн Өлзийсайхан нь Монгол Улсын Хууль зүйн сургуульд болон Багийн их сургуульд эхлээд 4 жил нийтдээ 19 жил багшилж, эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй, парламент судлалын чиглэлээр 10 гаруй

нэг сэдэвт бүтээл, ном, гарын авлага туурвиж, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл судалгааны ажил бичиж, эрдэмтэн судлаачид болон олон нийтийн хүртээл болгосон ийм Үндсэн хууль судлаач хүн.

Мөн чиглэлээрээ шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох үйл ажиллагааны практикийг судлах чиглэлээр АНУ, ХБНГУ, Япон, Франц, Солонгос, Швейцарын холбооны улсуудад мэргэжил дээшлүүлсэн. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, дэд профессор цолтой ийм хүн.

1998 оноос эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр тасралтгүй 25 жил ажиллаж байна. 1998-2002 онд Улсын багшийн их сургуульд, 2002-2016 онд Монгол Улсын Хууль зүйн сургуульд багш, ахлах багшаар ажилласан.

2 дугаарт нь, хууль тогтоох салбарт буюу Улсын Их Хуралд 2007 оноос эхэлж ажиллаж, мерит зарчмаар өгсөн дэвшиж, өнөөдөр Улсын Их Хурлын Тамгын газар Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа. Улсын Их Хурлын Тамгын газарт 2007 оноос эхлэн зөвлөх, экспертний хэсэг хариуцсан ахлах зөвлөх зэрэг ийм ажлуудыг хийж байсан бол 2013-15 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын дарга, 2015-2017 онд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байсан ийм шүүх эрх мэдлийн салбарт ажиллаж байсан туршилагатай.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлага зохицуулалтын газрын даргаар 2018 оноос 19 онд ажилласан. Ингээд 2019 оноос Улсын Их Хурлын Тамгын газарт Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Мөн Өлзийсайхан нь 2019 онд болон энэ онд оруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн

төслийг боловсруулах эхний шатаас хэлэлцэн батлах хүртэл бүхий л үйл явцад Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангах, судалгаагаар хангах ажлыг хариуцаж, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан ажиллаж, Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан. Тодруулбал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын хариуцлага, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн парламентын эрх зүйн орчны болон бусад шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монголд парламентын ардчиллыг бэхжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр үр дүнтэй ажиллаж байна.

Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн төслийг ард иргэдээр хэлэлцүүлэх, санал авах, улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаар Үндэсний хэмжээний зөвлөлдөх санал асуулга явуулах зэрэг төрийн ажил хэрэг, томоохон түүхэн үйл хэргүүдийг зохион байгуулахад бодлого, хэрэгжилтийн түвшинд мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж хариуцлагатай ажилласан.

Иймд Үндсэн хуулийн цэцийн гишүүнд тавигдах хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй гэсэн үндсэн шаардлагыг хангаж байгаа, хууль зүй эрдэм шинжилгээний судалгаанаас эхлэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт 25 жил хууль, эрх зүйн мэргэжлийн ажил эрхэлж буй Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Занданшатар даргад баярлалаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд

оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар, нэр дэвшигч өөрөө Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Лувсандоржийн Өлзийсайхан.

Нэр дэвшигчийн танилцуулга болон нэр дэвшигчийн танилцуулгыг бол бүх гишүүдэд тараагаад өгсөн байгаа. Ингээд энэ танилцуулга болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Ганбат гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Лувсандоржийн Өлзийсайхан гишүүнийг, даргыг дэмжиж байгаа. Эзэмисэн мэргэжил, ажлын дадлага туршлага, олж авсан арвин их туршилагатай ийм хүн. Цэцийн гишүүнд нэр дэвшиж орж ирж байгаа 3 нэр дэвшигч бол гурвуулаа энэ шаардлагыг хангасан ийм хүмүүс байгаа учраас гурвууланг нь дэмжиж байгаа.

Тэгээд Өлзийсайхан даргын хувьд болон Үндсэн хуулийн эрх зүйн шинэчлэлийг хийхэд, ард түмний засаглах эрхийг хамгаалахад, парламентын засаглалыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, гардан хийлцэж байсан ийм хүн. Тийм учраас таныг дэмжиж байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүн болсон хойно чинь бол юм хэлж чадахгүй. Нэр дэвшигч байгаа үед чинь бол бас нэг зүйлийг хэлэхэд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үед бас Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж дүгнэлт гаргаж байсан. Тийм учраас Үндсэн хуулийн цэц гэдэг бол Үндсэн хуулийн манаач болохоос биш Үндсэн хууль дотор байгаа ийм Үндсэн хууль зөрчсөн гэдэг ийм зүйл бас ярьдаг ийм газар биш ээ гэж ингэж бодож байгаа. Үүнийг та бас цаашидаа нэлээн сайн анхаараарай.

2 дахь нь, төрийн нууц, албаны нууц, Монгол улсын язгуур эрх ашиг, аюулгүй байдал, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, бие даасан байдалтай холбоотой аливаа нэгэн хууль тогтоомжийн асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргахдаа нэлээн сайн мэргэжлийн байгууллагуудаас судалгаа авч байхгүй бол санаатай бөгөөд санамсаргүйгээр үндэсний аюулгүй байдалд хор хохиролтой тийм заалтуудыг Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлүүлэх замаар гаргах гэж оролдож байгаа оролдлогууд гарч байгаа гэдгийг бас би энд хэлэх гэсэн юм. Тэгээд таны ажилд амжилт хүсье.

Д.Цогтбаатар: Асуулт асуугаагүй тийм ээ. Тэгвэл Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Ерөнхийдөө Өлзийсайхан даргыг бол дэмжиж байна. Харин бас нэг нүдээ олсон ийм нэр дэвшигчийг Улсын Их Хурал оруулж ирж байна гэж ойлгож байна. Тэр тусмаа манай ангийн дарга, Улсын Их Хурлын дарга маань хууль тогтоох байгууллагадаа хүндэтгэлтэй хандах ёстой гэдэг зүйлийг удаа дараа ярьдаг. Өнөөдрийн Байнгын хороо дээр өөрөө орж ирж нэр дэвшигчийг танилцуулж байгаа нь бас үүний нэг илэрхийлэл байна. Хүн хэлж ярих нэг өөр хэрэг, тэрийгээ өөрөө биеэрээ манлайлан үзүүлэх өөр хэрэг ээ. Яг бусад дарга нар ингэж ажилламаар байна. Улсын Их Хуралтай гэдгийг нэг сануулаад хэлчихье.

Өлзийсайхан дарга маань 12-16 онд бас Хууль зүйн сургуульд багшилж байсан байна. Бүх шаардлагуудыг хангаж л байна л даа. Үлгэр жишээ нэр дэвшигч байна. Сүүлийн үед бас Үндсэн хуулийн цэц рүү энэ МУИС-д багшилж байсан ийм хүмүүсийг 4, 5-аар нь явуулсан. Би өөрөө ч гэсэн тэнд сурч байсан, маш сайн сургууль. Гэхдээ сүүлийн үед өмнө нь ажиллаж байсан эрдэмтэн, багш нараа нэлээн жоохон тийм нэг том дарга болчихоороо нэг

сонин маягтай, дээрээс нь харах маягтай, үгүйсгэсэн маягтай ингээж харьцаж байгаа. Тэр янз бүрийн байдлаар илэрдэг. Тэд нарын эрдэм бол тэр анхнаас нь явсан тэр багш нараас эхлэлтэй. Тэр талаараа мэдээж хэрэг та тэр очоод хамт ажиллах хүмүүстээ бас хэлж ярьж ингээж ойлгуулаарай.

Нөгөө талаар та сая Их Хурлын даргын Их Хурлаас даргын танилцуулж байгаагаар бол нэлээн олон ном бичсэн гэж байна. Энэ хууль зүйн шинжлэх ухаантай холбоотойгоор. Тухайлбал ямар ямар чиглэлээр ямар ямар ном бичсэн юм бэ? Тэрийгээ та нэг бас нэг танилцуулбал зүгээр байх юм. Тэгээд таныг бол дэмжиж байна. Тийм. Амжилт хүсье.

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон өгье.

Л.Өлзийсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр миний бие парламент, парламентат ёс, парламентын хуралдааны дэгийн онол арга зүйн үндэс, Үндсэн хууль бүтээх үү, мөн одоо хууль дээдлэх ёс гэсэн ийм бүтээлүүдийг бол эрх зүйн түүх, дээж түүх эд нар гэсэн номуудыг бол ингээж хамтын болоод ингээд нэг сэдэвт ийм бүтээлүүдийг бол гаргасан байгаа. 20 орчим өгүүллүүдийг ингээж бичсэн байгаа.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүнд 1 минутыг нэмж өгье.

Д.Ганбат: Өлзийсайхан даргатай бол 3 жил гаруй сайхан хамтарч ажиллаж байна. Би АН-ын бүлгийн даргаар бол маш цөөхөн гишүүнтэй, 3 жил ажилласан. Энэ хугацаанд бол ингээд байнга харьцаж байсан. Энэ үед бол дандаа л хуулийг дээдэлж, хууль дээр яг ийм байна, хуулийн дагуу ийм учраас ингэх ёстой, таны хуулийн дагуу тавьж байгаа шаардлага зөв байна, үүнийг би биелүүлж ажиллая гэж ингээж ажиллаж

байсан нь бас манай парламентат ёсонд бол түүхийн хөгжилд бол бас ингээд бодитоор их хувь нэмэр оруулсан маш цөөнхтэй байгаа ийм парламентад. Тэрийг бас би тэмдэглээд хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Сая үнэхээр тэр парламентын талаар, Их Хурлын талаар нэлээн олон тийм сэдэвт нэг сэдэвт ... /минут дуусав/

Д.Цогтбаатар: Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Үг хэлэх гишүүд алга байна.

Өлзийсайхан даргад би хандаад бас танд амжилт хүсье. Ер нь Улсын Их Хурлаас өөрөө нэр дэвшиж байна гээд. Монгол Улс бол парламентын засаглалтай орон. Тэгэхээр та энд Үндсэн хуулиараа хууль тогтоох дээд байгууллагаас нэр дэвшээд явж байна гэдэг бол танд хамгийн их итгэл найдвар бас дайлгаж, даалгаж явж байгаа. Тэгээд амжилттай ажиллаарай.

Ингээд Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцийн гишүүнд санал болгосон нэр дэвшигч Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Миний юу машин ажилласангүй. Тийм учраас миний саналыг дэмжсэнд тооцоод оруулаарай.

Ингээд Өлзийсайхан даргад амжилт хүсье.

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Ганибалын Амартүвшин гишүүн. Тэгвэл Бямбацогт гишүүн танилцуулна. Гурвууланг нь шууд

нэгтгээд та танилцуулах болчихлоо шүү.
Тэгье.

зөрөөтэй саналын томъёоллыг
бэлтгэлээ.

18.05 цаг

Хэлэлцэх дараагийн асуудалдаа
оръё.

**Эрүүгийн хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүдийг хэлэлцье.**

Хуулийн төслүүдийг Байнгын
хорооны болон чуулганы нэгдсэн
хуралдаанаар хэлэлцүүлэх, санал,
дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг
бүхий ажлын хэсгийн танилцуулгыг
ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын
гишүүн Сандаг-Очир танилцуулна.
Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны
дарга, эрхэм гишүүд ээ, Эрүүгийн хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг
Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр
сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн
хуралдаанаар хэлэлцэж, эцсийн
хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн
байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын
чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт
орлуулах тухай хуулийн төслийн 3 дугаар
зүйлийн 2 дахь заалтын 3 дахь хэсэгт
шүүгч, прокурор, хууль сахиулагч,
өмгөөлөгч гэж нэмэхээр, мөн чуулганы
нэгдсэн хуралдаанаас Зөрчлийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь
заалтын 8 дахь хэсгийг гүйцээн
боловсруулах чиглэл авсан бөгөөд
чуулганы нэгдсэн хуралдааны анхны
хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан
саналуудыг төсөлд нэмж тусган
төслийн эцсийн хувилбар болон зарчмын

Эрүүгийн хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүдийн эцсийн хувилбарын төсөл,
эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай
танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж
өгөхийг та бүхнээс хүсье.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа
асуудалтай холбогдуулан хуралдаанд
оролцож байгаа албан тушаалтнуудыг
танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, УЕП-ын орлогч
Төрийн хууль цаазын шадар зөвлөх
М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын
туслах прокурор, Шүүхэд төрийг
төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар,
ЦЕГ-ын Захиргаа удирдлагын газрын
дарга Л.Нямдаваа, Тээврийн цагдаагийн
албаны Зөрчил шалган шийдвэрлэх
хэлтсийн дарга Ц.Чинзориг, Тээврийн
цагдаагийн албаны Мөрдөн шалгах
хэлтсийн дарга В.Хосбаяр, Хууль зүйн
үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-
Ундрах, Дотоод хэргийн их сургуулийн
Эрдэм шинжилгээний нэгдсэн
хүрээлэнгийн захирал, доктор, дэд
профессор С.Гантулга, Эрүүгийн хууль
тогтоомжийн уялдаа холбоог хангах
боловсронгүй болгох чиг үүрэг бүхий
байнгын ажлын хэсгийн гишүүн
Б.Гантуяа, Хууль зүй, дотоод хэргийн
яамны Хууль зүйн бодлогын газрын
шинжээч Т.Нарантунгалаг, Хууль зүй,
дотоод хэргийн яамны Хууль зүйн
бодлогын газрын мэргэжилтэн
Ц.Лхагвацэнд гэсэн бүрэлдэхүүнтэй
ажлын хэсэг байна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн
төслийн юу гишүүдэд бол тараасан
байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан
асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү?
Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Энх-
Амгалан гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан: Би хуулийн төсөлтэй холбоотойгоор энэ тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэдэг дээр хэрвээ энэ тээвэр энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 5-аас дээш жил, 8 жил хүртэл хугацаагаар хасаад, 1 жилээс 5 жил хүртэл зорчих эрхийг нь хязгаарлах буюу эсвэл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж байгаа юм. Тэгэхээр хүний амь нас хохирчихсон бол 1 жилээс 5 жил хоригдох юм уу. Энэ юу гэж ойлгох вэ? Үүнийг нэг тайлбарлаж өгөөч. 1 дэх нь.

2 дахь нь, энэ зүйлийн 5 дугаарт байна л даа. 3 дахь хэсгийн заасан гэмт хэргийг гээд. Тэгээд 5 дугаар хэсэг дээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсвэл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг 1 жилээс 3 жил хүртэл хугацаагаар хасах, 2700 нэгжээс 14 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгох, эсвэл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, 6 сараас 3 жил хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсвэл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих эрх шийтгэнэ гээд.

Энэ маань тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан буюу согтуурсан мансуурсан хүн энэ зохих журмын дагуу шалгуулахгүй байх ийм нөхцөл рүү түлхчих юм биш биз дээ. Энэ чинь заавал шалгуулах ёстой биз дээ. Мансуурсан уу, үгүй юу гэдгийг нь цусаар шалгуулдаг, архи дарс уусан уу, яасан уу гэдгийг нь заавал шалгуулж тэр согтолтын зэргийг нь тогтоох ёстой биз дээ л гэж би хэлээд байна л даа. Энэ 2 дээр нэг хариулт өгөөдхөөч.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг хэн хариулах вэ? Мөнх-Эрдэнэ зөвлөх 3 дугаар микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ, энэ замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчиж байгаа энэ гэмт хэрэг бол гэм буруугийн хувьд болгоомжгүй үйлдэгдсэн гэмт хэрэг гэж үзэж, манай Эрүүгийн хуульд ингээж зүйлчилж ирсэн байдаг, ингээж томъёолж ирсэн байдаг. Тийм учраас яг энэ уламжлалын дагуу томъёолол ер нь орж ирж байгаа гэдгийг хэлье. Ер нь энэ практик дээр бол манай энэ Зөрчлийн хууль дээр ч л байж байгаа согтуурсан, мансуурсан үедээ цагдаагийн албан хаагч нарт шалгуулахгүй зугтаадаг. Энэ тохиолдол олон. Тийм учраас энийг бас яг өмнөх энэ чинь тодорхой шалтгаантай учраас шалгуулахгүй зугтааж байгаа. Ийм тохиолдол гардаг. Тэгэхээр энийг бол яг манай Зөрчлийн хууль, Эрүүгийн хуульд одоо ч гэсэн байгаа. Энэ гэм буруутай гэж үзээд энэ өөрөө зугтаж шалгуулахаас зайлсхийж байгаа учраас ингээж хариуцлагыг нь тооцож ирсэн байдаг гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу болон ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. 2 саналтай байгаа.

Би энэ зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх

заалтын дагуу хураалгах санал, гүйцээн боловсруулах.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

8. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана. Хүн, хуулийн этгээд, эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд биелүүлээгүй нь цагдаагийн албан хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусгах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эс үгүй бол бусад аргаар хөдөлгөөнийг хязгаарлана.

Ингээд энэ томъёоллоор санал хураалт явуулъя. Саяын томъёоллыг энэ уншсан томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтаа явуулъя.

60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Би дэмжсэн санал өгсөн. Энэ ажлын хэсгийнхээ юунд техникийнхэн миний саналыг дэмжсэнд тооцож оруулаарай.

2 дахь асуудал. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтын дагуу хураалгах санал.

1. Төслийн 2 дахь заалтын 21.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “мөрдөн шалгах” гэсний өмнө “шүүгч, прокурор, хууль сахиулагч, өмгөөлөгч” гэж нэмэх. Үүгээр энэ томъёоллоор дэмжье гэсэн санал юу, томъёоллоор санал хураая.

Энэ дээр би гишүүдэд 1 зүйлийг сануулж хэлмээр байна. Энийг юу, босгохын тулд бол 3-ны 2-оор санал өгөгдөх ёстой, дэмжигдэх ёстой. Энэ тохиолдолд энэ чуулганд бол энэ томъёоллоороо орно. Санал хураалт явуулъя.

Санал хураалтыг түр зогсооё. Энэ юу, техникийнхэн наашаа ирээд миний энэ юуг нэг үзээдэх дээ. Энэ санал өгч болохгүй байгаад байгаа.

Саяын томъёоллоор ингээд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Юу дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ арай байхгүй, намайг дэмжсэнд тооцоорой. Ингээд энэ санал 3-ны 2 чинь 70 хувиар дэмжигдлээ. Ингээд 2 дахь асуудал хэлэлцээд, санал хураалтын дүн 70 хувиар саяын томъёолол ингээд дэмжигдлээ.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очир гишүүн танилцуулна.

18.20 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг

бууруулах, гэрийн хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуух гишүүд алга байна.

Би энд юу хэлэлцүүлэх асуудалтай холбогдуулаад ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Дэлгэрсайхан сайд өөрөө байгаа юу, хэн тэгээд танилцуулах юм? Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Пүрэвийн Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Дорждэрэмийн Цолмон, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Жаргалсайханы Ичинноров, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Газар чөлөөлөх хэлтсийн дарга Насанбатын Мөнхбаяр, Тээврийн цагдаагийн алба ЗЦГ-ын Замын хөдөлгөөний хяналт зохицуулалт хариуцсан дэд дарга, цагдаагийн

хурандаа Чадраабалын Батболд, Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга Ганбатын Ганхүү, Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Доржготовын Хан-Уул, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Дангаагийн Авирмэд гэсэн бүрэлдэхүүн байна.

Ингээд хуулийн төслийг Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна.

Тэгэхээр ингэнэ ээ. Одоо энэ дээр зарчмын зөрөөтэй санал би Байнгын хорооны гишүүний хувьд гаргаж байна. Тэгэхээр 2 санал байна. Зөрчлийн хууль дээр.

Тэгэхээр энэ яг хуультай холбогдуулаад төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “торгох шийтгэл” гэсний өмнө “Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан оногдуулсан” гэж нэмэх. Энэ ингээд саналаар энэ томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг түр хүчингүй болгоё. Саяын саналыг хүчингүй болгоё. Санал хураалтыг түр зогсоосон.

Энэ Хууль зүйн байнгын хорооны гишүүд хуралдаандаа орж ирэхийг урьж байна.

Гишүүд ээ, энэ машин орж гараад ажиллахгүй байгаа учраас би горимын

санал гаргамаар байна. Гараа өргөөд санал хураалтаа явуулчихъя. Энэ дээр заавал машин гэхгүйгээр шууд гараа өргөөд санал хураачхаж болно шүү дээ, тийм ээ. Тэгвэл ийм саналаар санал хураалт явуулъя.

Ингээд гишүүдийн олонхоор дэмжлээ. Ингээд гар өргөөд санал хураалт явуулчихъя.

Тэгэхээр нөгөө саналын зөрөөтэй юугаа, надад аваад ир дээ, томъёоллоо. Би дахиад уншаад гишүүдэд танилцуулчихъя. Сая та нарыг олируулаад өг гээд явуулсан шүү дээ.

Ингээд саяын түрүүн гаргасан, уншиж танилцуулсан зарчмын зөрөөтэй саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Ингээд оролцсон гишүүдийн ихэнх дэмжсэнээр саяын юу санал дэмжигдлээ.

Дараагийн. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан найруулгын санал бас байхгүй байгаа тул дараагийн зүйл рүүгээ ороод явъя.

Нийслэлийн Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллын гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Найруулгын юу санал бас байхгүй байгаа.

Нийслэлийн Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Бичгээр гаргасан санал байхгүй байгаа. Найруулгын чанартай бас санал байхгүй байгаа.

Тэгвэл ингээд дагалдах дараагийн хууль руугаа орёе. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Бичгээр гаргасан бас төсөлтэй холбогдуулан бичгээр гаргасан санал байхгүй байгаа. Найруулгын чанартай бас санал байхгүй байгаа.

Өргөн мэдүүлсэн дараагийн хуулийг танилцуулъя. Нийслэл Улаанбаатар хотын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Бичгээр гаргасан санал байхгүй байгаа. Найруулгын чанартай бас санал байхгүй байгаа.

Өргөн мэдүүлсэн ингээд дуусаж байгаа юм байна шүү дээ. Тэгвэл ингээд Улаанбаатар хотын.

Саяын энэ юу хэлэлцүүлсэн асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороонд Хууль зүйн байнгын хорооны гишүүн, Цэндийн Мөнх-Оргил танилцуулна.

Ингээд энэ асуудал дууслаа.

18.40 цаг

Тэгэхээр өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа.

Байнгын хорооны хуралдаан дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ